



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 05 өдөр

Дугаар АР/68

Булган сум

Хөрөнгө бүртгэлд авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 6.2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 798 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021, 2023, 2024 онуудад ашиглалтад орсон, Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжиж байгаа Дашинчилэн сум 1.8 км хатуу хучилттай авто зам, Хангал сумын Хялганат тосгоны Хангал-Хялганат эхлэлийн 10 км хатуу хучилттай авто зам, Булган сум 4 дүгээр баг Зүүн түрүү 1.8 км хатуу хучилттай авто замыг данс бүртгэлд авах 8,248,337,945 (найман тэрбум хоёр зуун дөчин найман сая гурван зуун гучин долоон мянга есөн зуун дөчин тав) төгрөгийн хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар баталсан хөрөнгийг сум, байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор хүлээн авч, данс бүртгэлд бүртгэсэн тайланг 2026 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга, тосгоны Захирагч нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, 2025 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайланг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай тооцоо нийлж баталгаажуулахыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.ЛҮРЭВ-ОЧИР



6326010219

03 Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын 05 -ны/ний өдрийн
... дугаар захирамжийн хавсралт



ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт үнийн дүн	Өмчид бүртгэж авах сум, байгууллага, улсын комиссын акт огноо, дугаар	ТӨБЗГ-ын тогтоолын огноо, дугаар,
1	2	3	4	5	6	7
1	Дашинчилэн сум 1.8 км хатуу хучилттай авто зам	км	1.8	1,439,292,989	Дашинчилэн сумын ЗДТГ 2023-12-21 Дугаар 13/014/23	2025-12-24 Дугаар 798
2	Хангал сумын Хялганат тосгоны Хангал-Хялганат эхлэлийн 10 км хатуу хучилттай авто зам	км	10.0	5,289,033,703	Хялганат тосгоны ЗАА 2024-07-09 Дугаар 11/2/2024	2025-12-24 Дугаар 798
3	Булган сум 4 дүгээр баг Зүүн түрүү 1.8 км хатуу хучилттай авто зам	км	1.8	1,520,011,253	Булган сум Тохижилт үйлчилгээний анги 2021-12-06 Дугаар 6/11/21	2025-12-24 Дугаар 798
Нийт дүн				8,248,337,945		

--o00o--